



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 9/20

Мандалговь

Г Эрх шилжүүлэх тухай Г

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6, 46 дугаар зүйлийн 46.2, 46.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 21 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 21 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтын хоёр дахь хэсэгт тусгагдсан “Сайхан-Овоо сумын Соёлын төвийн их засвар” ажлын 250,000,000 (хоёр зуун сая) төгрөг, тав дугаар хавсралтын 2.3.5 дахь хэсэгт тусгагдсан “Өндөршил сумын ерөнхий төлөвлөгөө боловсруулах” 100,000,000 (нэг зуун сая) төгрөгийн төсөл арга хэмжээг тухайн сумдад тус тус эрх шилжүүлсүгэй.

2. Эрх шилжүүлсэн ажлыг холбогдох хуулийн дагуу сонгон шалгаруулж, гүйцэтгэлийн үр дүнгээр санхүүжүүлэхийг Сайхан-Овоо сумын Засаг дарга (С.Амарсанаа), Өндөршил сумын Засаг дарга (У.Алтанхүү), эрх шилжүүлсэн арга хэмжээний явцын мэдээллийг сар бүрийн 2-ны өдрийн дотор Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст тайлагнаж ажиллахыг дээрх сүмдүүн Засаг даргын Тамгын газрын дарга нарт даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (С.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭЧ И/ХОЛ Л.ДОРЖБАТ

4820159050